



Багануур дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ны 24 дүгээр тогтоолийн 1-р хавсралт

ДҮҮРГИЙН ОНЫ ТЭРГҮҮНИЙ БАЙГУУЛЛАГА, ХОРОО, АЖ АХУЙН НЭГЖ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хороо, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагыг чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан дараах байдлаар шалгаруулна. Үүнд:

1.1. Төрийн захиргааны байгууллага /ЗДТГазар, Татварын хэлтэс, НДХэлтэс, ХХҮХэлтэс, МХХэлтэс, ЦХэлтэс, ОБХэлтэс, Боловсролын хэлтэс, Статистикийн хэлтэс, Газрын алба, ШШГАлба, ХЦ-ийн 0252-р анги г.м /

1.2. Хороо / 1, 2, 3, 4 дүгээр хороо /

1.3. Төрийн үйлчилгээний байгууллага: /ЭМНэгдэл, Боловсрол цогцолбор, Цэцэрлэгүүд, Өргөө соёлын төв, Биеийн тамир спортын хороо, БГХӨСТөв, Хүүхэд хөгжлийн төв, Гэгээрэл хөгжлийн төв г.м /

1.4. Үйлдвэр аж ахуйн газар / Багануур ХК, БЗӨБЦТС ХК, Дулааны станц ХК, ТБЦДСүлжээ ХК, Багануур ус НӨҮГ, Авто жим НӨҮГ, Мэдээлэл холбооны сүлжээ ХК, МЦХ-ХК-ны Багануурын Холбооны газар г.м /

1.5. Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж / Улсын бүртгэлтэй байгууллага аж ахуйн нэгжүүд /

1.6. Иргэний нийгмийн байгууллагууд /Улсын бүртгэлтэй иргэний нийгмийн байгууллагууд /

Хоёр. Шалгаруулах нийтлэг үзүүлэлт

2.1 Шилдэг байгууллага, хороо, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн байгууллагыг шалгаруулахад дараах үзүүлэлтийг шалгуур болгоно.

2.1.1. Төрийн захиргааны байгууллага

2.1.2. Төрийн үйлчилгээний байгууллага:

-Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үзүүлэлт, үр дүн өмнөх оны түвшингээс ахисан байх.

-Дүүргийн төр захиргааны байгууллагатай хамтран ажиллаж эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын биелэлт 90-ээс доошгүй хувьтай байх.

-Байгууллагын удирдлагын манлайлал, нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлсэн байдал

-Санхүүгийн зөрчилгүй, төсвийн өр авлага үүсгээгүй байх.

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, тайлант мэдээний хугацаа хожимдоогүй байх.

-Дүүрэг болон байгууллага орчноо тохижуулах чиглэлээр шинийг санаачилж ажилласан байх.

-Ажилтнуудын ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байх.

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн.

-Үйл ажиллагаагаа иргэдэд сурталчилсан байдал, зохион байгуулсан сургалт сурталчилгаа, үр дүн

2.1.3 Хороо

-Хорооны үндсэн үйл ажиллагааны үзүүлэлт, үр дүн өмнөх оны түвшингээс ахисан байх.

-Нийслэл, дүүрэг, хорооны засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, үр дүнгийн гэрээний биелэлт 90-ээс доошгүй хувьтай байх.

-Хууль тогтоомж, тогтоол шийдврийн биелэлт 80-аас доошгүй хувьтай, тайлант мэдээний хугацаа хожимдоогүй байх.

-Хорооны иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээ, бүртгэл мэдээллийн /, хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогыг нэмэгдүүлэх талаар зохион байгуулсан ажил үр дүн.

-Эрүүл мэнд боловсролын салбарын чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн.

- Хорооны нутаг дэвсгэрийг тохижуулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр шинийг санаачилж хийсэн ажил, байр гудамж талбайн цэвэрлэгээ, хаягжилт, гэрэлтүүлгийн байдал

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн

-Үйл ажиллагаагаа иргэдэд сурталчилсан байдал, зохион байгуулсан сургалт сурталчилгаа, үр дүн

2.1.4. Үйлдвэр аж ахуйн газар

-Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үзүүлэлт, үр дүн өмнөх оны түвшингээс ахисан байх.

-Дүүргийн төр захиргааны байгууллагатай хамтран ажиллаж эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхой ажил зохион байгуулсан байх.

- Дүүргийн төсвийн бүрдүүлэлтэд тодорхой хувь нэмэр оруулж, төлсөн татварын хэмжээ жил дараалан нэмэгдсэн, татварын зөрчилгүй байх, нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн дагуу төлсөн байх.

- Хотын ерөнхий төлөвлөгөө болон Тухайн орчны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлтэй уялдуулан өөрийн хөрөнгөөр байгууллага орчноо үлгэр жишээ тохижуулсан байх.

- Үйлдвэрлэл үйлчилгээний байр нь эрүүл ахуйн хэм хэмжээг хангасан байхын зэрэгцээ ажлын байрыг нэмэгдүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой ажил зохиож үр дүнд хүрсэн байх

- Түүхий эд, эрчим хүчний хэмнэлт, бохирдол хаягдлыг багасгах, арилгах чиглэлээр техник технологийн шинэчлэлт хийсэн байх.

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн.

-Үйл ажиллагаагаа иргэдэд сурталчилсан байдал, зохион байгуулсан сургалт сурталчилгаа, үр дүн

2.1.5. Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж

- Үйлдвэрлэл үйлчилгээ нь тогтворжиж сүүлийн 2-оос доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх.

-Дүүргийн төсвийн бүрдүүлэлтэд тодорхой хувь нэмэр оруулж, төлсөн татварын хэмжээ жил дараалан нэмэгдсэн, татварын зөрчилгүй байх, ажилтнуудыг нийгмийн даатгалын шимтгэлд хамруулсан байх.

- Үйлдвэрлэл үйлчилгээний байр нь эрүүл ахуйн хэм хэмжээг хангасан байхын зэрэгцээ ажлын байрыг нэмэгдүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой ажил зохиож үр дүнд хүрсэн байх

- Үйлчилгээний шинэ дэвшилтэт хэлбэр нэвтрүүлэх талаар олсон амжилт, явуулж байгаа үйл ажиллагаа

- Хэрэглэгчдийг дээдлэх талаар явуулсан үйл ажиллагааны үр дүн

- Хог хаягдал нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх

-Өөрийн хөрөнгөөр байгууллага орчноо үлгэр жишээ тохижуулсан байх., цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийсэн байх.

- Сахилга, дэг журам бэхжүүлэх талаар гарсан хууль тогтоомжийг хэрэгжүүлж гэмт хэрэг зөрчил гаргаагүй байх

2.1.6. Иргэний нийгмийн байгууллагууд

- Үйл ажиллагаа нь тогтворжиж сүүлийн 2-оос доошгүй

жил тасралтгүй ажилласан байх.

- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны үзүүлэлт, үр дүн өмнөх оны түвшингээс ахисан байх.
- Дүүргийн төр захиргааны байгууллага, бусад иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх ажилд бодит хувь нэмэр оруулсан байх.
- Нийгмийн сайн сайхны төлөө зохион байгуулсан ажил, иргэд олон нийтийг хамруулсан байдал.
- Дүүрэг орон нутгаа хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, орчныг тохижуулах чиглэлээр шинийг санаачилж ажилласан байх.

- Гишүүд дэмжигчдийн санал санаачилгыг дэмжсэн байдал тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр ажилласан байдал.

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, үр дүн .

-Үйл ажиллагаагаа иргэдэд сурталчилсан байдал, зохион байгуулсан сургалт сурталчилгаа , үр дүн

3. Урамшуулах ажлын зохион байгуулалт

3.1 Энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу материалыг бүрдүүлж жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Засаг Даргын Тамгын Газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэх ба шаардлага хангаагүй материалыг хүлээн авахгүй болно.

3.2 Дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон комисс шалгаруулалтад ирүүлсэн материалыг хянан үзэж шаардлагатай бол газар дээр нь танилцсаны үндсэн дээр Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж шийдвэр гаргуулна.

3.3. Дүүргийн оны тэргүүний байгууллага, хороод , аж ахуйн нэгжийн шагналыг жил бүр Шинэ жилийн баярын үеэр гардуулна.

3.4 Шалгаруулалтад оролцох байгууллага ,хороод, аж ахуйн нэгжүүдийг дараах байдлаар дэвшүүлж болно. Үүнд

-Байгууллага, хороод, аж ахуйн нэгж өөрөө нэрээ дэвшүүлэх

-Иргэний нийгмийн байгууллагаас нэр дэвшүүлэх

-Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга

3.5 Шалгаруулалтад орох материал нь дараах бичиг баримтаас бүрдэнэ.

-Шалгаруулалтад орохыг хүссэн байгууллага, хороод, аж ахуйн нэгжийн албан бичиг

-Үйл ажиллагааны тухай/ журмын дагуу бүрдүүлсэн/ тодорхойлолт, танилцуулга

- Хорооны Засаг даргын тодорхойлолт

-Татварын болон хяналтын газрын тодорхойлолт

Дөрөв. Урамшууллын хэлбэр

4.1 Энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангасан салбар тус бүрт нэг байгууллага, хороо, аж ахуйн нэгжийг шалгаруулан Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Дарга болон Дүүргийн Засаг даргын батламжилсан өргөмжлөл, дурсгалын зүйлээр урамшуулна.

4.2 Оны тэргүүний байгууллага, хороо ,аж ахуйн нэгжээр шалгарсан байгууллагын үйл ажиллагааг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2 оос доошгүй удаа үнэгүй сурталчилна.

4.3. Энэ журмын дагуу олгох урамшуулалттай холбогдсон зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргана.

4.40. Хуурамч тодорхойлолт материал бүрдүүлж шалгаруулалтад оролцсон нь тогтоогдвол урьд олгосон оны тэргүүний байгууллага, хороо, аж ахуйн нэгжийн өргөмжлөлийг хүчингүй болгох асуудлыг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлж хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

Багануур дүүргийн Иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2010 оны 04 дүгээр сарын 14-ны 24
дүгээр тогтоолийн 2-р хавсралт

Дүүргийн оны тэргүүний хүмүүсийг шалгаруулах шалгуур үзүүлэлт

Нэг. Дүүргийн эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй ажиллаж байгаа, дүүрэг орон нутгаа улс нийслэлд сурталчилж байгаа ажилтан албан хаагчид, биеийн тамир, урлаг соёлын ажилтны төлөөллийг мэргэжил боловсрол, ажиллаж буй байгууллага аж ахуйн нэгжийн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан дараах байдлаар шалгаруулна. Үүнд:

1. Оны тэргүүний удирдагч

- Дүүргийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ болон тухайн байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 90-ээс доошгүй хувьтай байх.

- Хариуцсан байгууллагын үндсэн үйл ажиллагааны үзүүлэлт, үр дүн өмнөх оны түвшингээс ахисан байх

- Удирдлагын манлайлал, нийгмийн хариуцлагыг дээшлүүлсэн байх.

- Санхүүгийн зөрчилгүй, төсвийн өр авлага үүсгээгүй байх.

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, тайлант мэдээний хугацаа хожимдуулаагүй байх.

- Дүүрэг болон байгууллага орчноо тохижуулах чиглэлээр шинийг санаачилж ажилласан байх.

- Ажилтнуудын ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байх.

- Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал, сургалт сурталчилгаа зохион байгуулсан байдал

2. Оны тэргүүний төрийн жинхэнэ албан хаагч:

- Тухайн байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх.

- Сүүлийн 2 жилд байгууллагын хөдөлмөрийн аварга тэргүүний ажилтнаар шалгарсан байх.

- Засаг даргын мөрийн хөтөлбөр, дүүргийн эдийн засаг нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан байх.

- Төсвийн ерөнхий менежер, нэгжийн менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт 90-ээс доошгүй хувьтай байх.

- Төрийн ажил үйлчилгээг иргэдэд хүргэх, хууль сурталчлах чиглэлээр шинийг санаачилсан байх.

- Төрийн албан хаагчийн ёс зүй, нэр хүндэд харшилсан зөрчилгүй байх

3. Оны тэргүүний эрүүл мэндийн ажилтан

- Тухайн байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх.

- Сүүлийн 2 жилд байгууллагын хөдөлмөрийн аварга тэргүүний ажилтнаар шалгарсан байх

- Ажил олгогчтой байгуулсан хамтын гэрээний заалтыг бүрэн хэрэгжүүлсэн байх

- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд тодорхой ажлыг санаачилж үр дүнд хүрсэн байх.

- Үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж тэдгээрийн талархалыг хүлээсэн байх.

4. Оны тэргүүний боловсролын ажилтан

- Тухайн байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх.

- Сүүлийн 2 жилд байгууллагын хөдөлмөрийн аварга тэргүүний ажилтнаар шалгарсан байх

- Ажил олгогчтой байгуулсан хамтын гэрээний заалтыг бүрэн хэрэгжүүлсэн байх

- Бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр шинийг санаачилж тодорхой ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байх.

- Сургалтын шинэ дэвшилтэт арга хэрэгслийг ашиглаж амжилт гаргасан байх

- Сургалтын стандарт, тоо чанарын үзүүлэлтийг хангасан байх.

5. Оны тэргүүний санхүү, банкны ажилтан

- Тухайн байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх.

- Сүүлийн 2 жилд байгууллагын болон системийн хөдөлмөрийн аварга тэргүүний ажилтнаар шалгарсан байх

- Төсвийн ерөнхий менежер болон ажил олгогчтой байгуулсан үр дүнгийн гэрээ, хамтын гэрээний хэрэгжилт.

- Нягтлан бодох бүртгэлийн ОУ-ын стандартад нийцсэн бүртгэлийн бодлогыг баримт бичиг боловсруулж мөрдсөн байх.

- дүн
- Зардал хямдруулах, батлагдсан төсөв хэмнэх талаар тодорхой ажил санаачилж хийсэн байх, үр
 - Төсвийн ил тод байдлыг хангаж, өр авлага үүсгэхгүй, зөрчил дутагдалгүй ажилласан байх
 - Тайлан мэдээг цаг хугацаанд нь үнэн зөв гаргасан байх

6.Оны тэргүүний инженер техникийн ажилтан

- Тухайн байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх.
- Сүүлийн 2 жилд байгууллагын хөдөлмөрийн аварга тэргүүний ажилтнаар шалгарсан байх.
- Шинэ бүтээл үйлдвэрлэлд нэвтрүүлж тодорхой үр дүнд хүрсэн байх.
- Хариуцсан техник тоног төхөөрөмжүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангах техник зохион байгуулалтын оновчтой механизм бий болгосон.
- 2-оос доошгүй ажилтныг сургаж дадлагажуулан тодорхой амжилтанд хүргэсэн байх..

7.Оны тэргүүний ажилчин

- Тухайн байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх.
- Сүүлийн 2 жилд байгууллагын хөдөлмөрийн аварга тэргүүний ажилтнаар шалгарсан байх
- Ажил олгогчтой байгуулсан хамтын гэрээний заалтыг бүрэн хэрэгжүүлсэн байх
- Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, үр дүн хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил санаачилж хийсэн байх. .

8.Оны тэргүүний үйлчилгээний ажилтан

- Тухайн байгууллагад 3-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх.
- Сүүлийн 2 жилд байгууллагын хөдөлмөрийн аварга тэргүүний ажилтнаар шалгарсан байх
- Ажил олгогчтой байгуулсан хамтын гэрээний заалтыг бүрэн хэрэгжүүлсэн байх
- Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, үр дүн хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил санаачилж хийсэн байх.

9.Оны тэргүүний тамирчин:

- Дүүрэгт нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх үйлсэд тодорхой хувь нэмэр оруулсан байх.
- Улс нийслэл, бүс, дүүргийн уралдаан тэмцээнүүдэд амжилт гаргасан байх, гаргасан амжилт нь урьд оноос ахисан байх.

10.Оны тэргүүний соёл урлагийн ажилтан

- Дүүрэгт соёл урлагийг хөгжүүлэх үйлсэд тодорхой хувь нэмэр оруулсан байх.
- Дүүрэг, байгууллага, хамт олны дэмжлэгтэйгээр болон бие даан улс нийслэл, бүс, дүүргийн соёл урлагийн арга хэмжээнд амжилт гаргасан байх.
- Шинэ уран бүтээл гаргаж бүтээл нь олны хүртээл болсон байх.

11.Оны тэргүүний сурагч

- Улс нийслэл, бүс, дүүргийн төрөл мэргэжлийн хичээлийн олимпиадад амжилт үзүүлсэн байх.
- Улс нийслэл, бүс, дүүргийн биеийн тамир, соёл урлагийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан байх.
- Хичээлийн жилийн сурлагын дүн В /80/ -ээс доошгүй үзүүлэлттэй байх.
- Гамшиг ослоос хүний амь, бусдын өмч хөрөнгийг аварч хамгаалсан байх

12.Оны тэргүүний малчин

- Дүүрэг хороотой хамтран ажиллах, дүүргийн иргэдийг чанартай мал, мах, махан бүтээгдэхүүнээр хангасан байдал.
- Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохиож хэрэгжүүлсэн байдал
- Малын билчээр, билчээрийн даац, худаг ус, байгаль орчныг хамгаалах чиглэлээр санаачлагатай ажилласан байх
- Хашаа хороо, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан байдал
- Ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийг малжуулах чиглэлээр санаачилга гарган ажилласан байдал.

13.Оны тэргүүний тариаланч

- Дүүрэг хороотой хамтран ажиллах, дүүргийн иргэдийг чанартай хүнсний ногоогоор хангасан байдал
- Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлсэн байх
- Хүнсний ногоо тариалалт, талбайн аготехник, га-гаас авсан ургацын хэмжээ,
- Байгаль орчин, хөрс усыг хамгаалах чиглэлээр санаачлагатай ажилласан байх
- Ажлын түр болон байнгын байр бий болгосон байх.

14. Оны энэрэнгүй үйлстэн

-Нийгмийн сайн сайхны төлөөх үйлсэд өөрийн мэдлэг боловсрол, ур чадвар, хичээл зүтгэлээ дайчлан ажилласан байх.

-Хүн ардын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах үйлсэд өөрийн амь бие эрүүл мэндээ үл хамааран зориулсан байх.

-Дээрх үйлсэд хөрөнгө санхүүгийн бодитой дэмжлэг туслалцаа үзүүлсэн байх.

15. Оны онцлох хүн

-Улс төр, эдийн засаг, нийгэм, хэвлэл мэдээллийн бүхий л салбарт тухайн онд хийж бүтээсэн ажлаараа олны талархал хүлээж танил болсон байх.

-Дээрх үйлс нь дүүрэг орон нутгийн хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр үзүүлсэн байх.

1.2. Нэр дэвшсэн иргэн нь гэмт хэрэг болон захиргааны зөрчлийн холбогдолгүй ял шийтгэлгүй байна

2. Урамшуулах ажлын зохион байгуулалт

2.1 Энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу байгууллагын хүний нөөцийн менежерүүд, хорооны нийгмийн ажилтнууд иргэний материалыг бүрдүүлж жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Засаг Даргын Тамгын Газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэх ба шаардлага хангаагүй материалыг хүлээн авахгүй болно.

2.2 Дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон комисс шалгаруулалтад ирүүлсэн материалыг хянан үзэж шаардлагатай бол газар дээр нь танилцсаны үндсэн дээр Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж шийдвэр гаргуулна.

2.3 Дүүргийн оны тэргүүний хүмүүсийн шагналыг жил бүр Шинэ жилийн баярын үеэр гардуулна.

2.4 Оны тэргүүний малчин тариаланчдын материалыг дараа оны 2-р сарын 01-ний дотор хүлээн авч шагналыг сар шинийн баярын үеэр гардуулна.

3. Шалгаруулалтад оролцох хүмүүсийг дараах байдлаар дэвшүүлж болно. Үүнд:

3.1 -Байгууллага, хороод, аж ахуйн нэгж нэр дэвшүүлэх

-Иргэний нийгмийн байгууллагаас нэр дэвшүүлэх

-Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, Засаг дарга

3.2 Шалгаруулалтад орох материал нь дараах бичиг баримтаас бүрдэнэ.

-Шалгаруулалтад орох иргэнийг дэмжсэн байгууллага, хороод, аж ахуйн нэгжийн албан бичиг

-Үйл ажиллагааны тухай/ журмын дагуу бүрдүүлсэн/ тодорхойлолт, танилцуулга

-Гэмт хэрэг захиргааны зөрчлийн холбогдолгүй тухай Цагдаагийн байгууллагын тодорхойлолт

4. Урамшууллын хэлбэр

4.1 Энэ журамд заасан салбар тус бүрт шалгуур үзүүлэлтийг хангасан нэг иргэнийг шалгаруулан Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Дарга болон Дүүргийн Засаг даргын батламжилсан өргөмжлөл, дурсгалын зүйлээр урамшуулна.

4.2 Оны тэргүүний ажилтан, албан хаагчаар шалгарсан иргэний гаргасан амжилтыг орон нутгийн 7 хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2 оос доошгүй удаа үнэгүй сурталчилна.

4.3 Энэ журмын дагуу олгох урамшуулалттай холбогдсон зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргана.

4.4 Хуурамч тодорхойлолт материал бүрдүүлж шалгаруулалтад оролцсон нь тогтоогдвол урьд олгосон оны тэргүүний иргэний өргөмжлөлийг хүчингүй болгох асуудлыг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлж хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.